

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН 2014 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Д/д	Хийх ажлын үндсэн чиглэл	Дэд ажил	Биелэлт
1. Дотоод үйл ажиллагааны чиглэлээр			
1.1.	МТҮП-ын ашиглалтыг сайжруулах	Силикон хаус төслийн барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, барилгыг хүлээн авах, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах	Силикон хаус төслийн нээлт 5-р сарын 8-д болсон бөгөөд энэхүү арга хэмжээний зохион байгуулалтыг бүрэн ханган ажилтнуудад ажлыг хувиарлах, гүйцэтгэлд хяналт хийж ажиллахаас гадна үйл явдлын мэдээллийг салбарын төрийн байгууллагуудын веб хуудсанд нэг өдөр байрлуулах ажлыг зохион байгуулж ажиллаа.Нээлтийн үйл ажиллагаан 200 гаруй зочид төлөөлөгчид оролцсон Эрдэм шинжилгээний бага хуралд 70 гаруй хүн оролцож Эмбеддэд системийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүллээ. 5-р сарын 8-ны үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргасан.
		Гаражын дээврийн засварыг эхлүүлэх	Засварын ажлыг хийгдсэн.
		Сантехник, дулааны засвар үйлчилгээ	Зуны улиралд хийх засварын ажлын хүрээнд узелийн өрөөнд агааржуулалтын систем угсрах, халаалтын босоо шугамын засвар, гадна дулааны шугамын нягтын шахалт хийх зэрэг ажлыг гүйцэтгэв. Мөн бохирын болон бусад гэмтлийг цаг тухай бүр засч байв.
1.2.	Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах	Цагаан сарын үйл ажиллагаа зохион байгуулах	Байгууллагын сар шинийн золголт зохион байгууллаа. 2014 оны 1-р сарын 24 -нд 50 гаруй ахмад настанг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, Сар шинийн тавагийн идээ өгөв.
		Өглөөний цай арга хэмжээ зохион байгуулах	2014 оны 1 , 5-р саруудад өглөөний цай арга хэмжээг зохионб байгууллаа. 1-р сарын хүндэт зочиноор МУИС-н багш философич Жамбал багш хүрэлцэн ирж бидний өглөөний цай арга хэмжээнд оролцов. 5-р сарын Өглөөний цай арга хэмжээний үеэр эх үрсийн баярыг тохиолдуудан ажилчидынхаа хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн Эх үрсийн баярын бэлэг гардууллаа.
		Биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортоор хичээллэх үйл ажиллагаа зохион байгуулах	Ажилчид өөрсдийн эрүүл мэнд, хөдөлгөөндөө анхаарч 7 хоногийн 2 дахь өдөр бүр спорт зааланд очиж алжаал ядаргаагаа гаргаж байна. Цахилгаан холбоо ХХК-тай гэрээ байгуулан ажилтнуудыг 7 хоногт 3 удаа фитнесээр хичээллэх боломжийг бүрдүүлсэн. Ажилтнууд идэвхтэй хамрагдаж байна.

		Бүх ажилчдыг эмнэлгийн үзлэгт хамруулах	2014 оны 05-р сард нийт 26 ажилтанг БГЭМН-ын 11 нэрийн мэргэжлийн эмч үзлэг, шинжилгээнд хамруулсан. Цаашид ажилтан ажилчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах төлөвлөөд байна.
		Харилцаа холбооны 93 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төрийн болон салбарын шагналд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах	Ажилдаа үр бүтээл гаргасан ажилтнуудаа салбарын шагнал урамшуулалд тодорхойлж Салбарын 93 жилийн ойн баяраар "Салбарын тэргүүний ажилтан" цол тэмдэгээр-1, "Салбарын жуух" бичгээр-1 ажилтан шагнагдлаа.
		Байгууллагын ажилчдын нийгмийн асуудалд чиглэсэн үйл ажиллагаа явуулах	Хас банк болон Сайн компьютерс тай хамтран ажилчдыг урт хугацааны Зээлийн үйлчилгээнд хамрууллаа.
		Байгууллагын зуны аялалын маршрутыг гарган батлуулах, зохион байгуулах	Зуны аялалын маршрут, төсөв, төлөвлөгөөг гарган тушаалыг батлуулан бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаа. Зуны аялалыг 6-р сарын 23-29 өдрүүдэд УБ-Хөвсгөл хүртэл тойрон аялал хийж Монгол орныхоо үзэсгэлэнт байгалтай танилцлаа. /Нийт 25 хүн хамрагдсан/
		Цасны баяр	Цасны баярын арга хэмжээ 3-р сард зохион байгуулж Тэрэлжийн сав газрын үзэсгэлэнт байгалтай танилцаа.
1.3.	Хүний нөөцийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих	Байгууллагын хамтын ажиллагаа, ажлын байрны соёл, ёс зүйн болон бусад сургалт зохион байгуулах	Байгууллагын ажилчдын ёс зүй болон мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх үүднээс 6-р сарын 16 өдөр авлигатай тэмцэх газрын "Авлига, ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. /хамрагдсан 12/
		Ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх мэргэжлийн сургалтанд ажилтнуудыг хамруулах	ӨТХТ-н ажилтан Ж.Даваахүү Enterprise Architecture /togaf framework/ сургалтанд хамрагдаж 2014 оны 1-р сарын 28 өдөр Togaf 9 certification гардаж авлаа. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж Австрали улсын CC and C solutions байгууллагын мэргэжилтэн хичээл заасан.
			ӨТХТ-н ажилтан Ж.Даваахүү Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан Archimate tool -ийн сургалтанд 2014.03.10-14 өдрүүдэд хамрагдаж, шалгалтаа 5 сард өгч Archimate Tool -ийн сертификатай боллоо.
		Ажилчдын мэдлэг ур чадварийг дээшлүүлэх, мэргэшүүлэх үүднээс 4/22-4/23 өдөр Ц.Түвшинтөр Ганабелл төвийн "Гэрээ хэлэлцээр хийх урлаг" сургалтанд, 5/15-5/20 хооронд СБХТ-н ажилтан Сургалт хариуцсан мэргэжилтэн Г.Энэрэлт, Гадаад харилцаа, Маркетингийн мэргэжилтэн Б.Заяажаргал нар Лектор төвийн "Мастер маркетер" сургалтанд хамрууллаа.	

			<p>ТӨХ-оос зохион байгуулсан худалдан авах ажиллагааны системд нэвтрэх эрх олгох сургалтанд үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Ганцэцэг сууж өөрийн нэр дээр эрх авахаар бүртгүүлээ.</p> <p>Паркын ажилтнуудын хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор англи хэлний сургалтанд хамруулж байна. АВС 3 групп хувааж нийт 16 ажилтан хамрагдаж байна.</p> <p>БНЭУ-д нэг ажилтныг Хүний нөөцийн мастерт хамруулж байна</p>
		Ажлын байрны зар, мэдээллийг явуулах	Ажлын байрны сул орон тоо болон эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил дээр тогтмол зар мэдээллийг өөрийн веб сайт болон FB хуудас Biznetwork зэрэг худсаар зарлал мэдээллийг явуулж байна. Зарлал мэдээллийн дагуу 40 гаруй ажил гориллогчийн анкетийг CV -г бүртгэж авсан бөгөөд сонгон шалгаруулалтаар ЗХНГ-т Нярав, ӨТХТ-д Програм хангамжийн инженерийг тус тус зохих журам хууль дүрмийн дагуу шалгаруулан авч Хөдөлмөрийн гэрээ АБТ-ыг гаргаж өгөөд байна.
1.4.	Байгууллагын эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн асуудлыг шийдвэрлэх	Шүүхийн шатанд шилжсэн болон цаашид шилжүүлэх шаардлагатай хэрэг маргаан дээр байгууллагыг төлөөлж ажиллах	Нийт 8 шүүх хуралд оролцож, нэхэмжлэл 7 удаа, хүсэлт 10 удаа, тайлбар 11 удаа Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх болон Нийслэлийн давж заалдах шатны шүүхэд гаргаж нотлох баримтыг бүрдүүлж, тухай бүр хавтаст хэрэгтэй танилцаж /нэмэлт тайлбар, хүсэлт, нотлох баримт гаргасан тухай бүрт/, шүүгч болон шүүгчийн туслахтай уулзаж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу процессийн ажиллагааг хийж ажиллаа.
		Шаардлагатай бүх дүрэм, журам, заавар, эрх зүйн бичиг баримтуудыг шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах, мөрдлөг болгохтой холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Хөдөлмөрийн дотоод журам, Хяналт, шалгалтын журам, Архивын үйл ажиллагааны журам, Инкубаторын үйл ажиллагааны журам, Нууцын журам, Хаяг, реклам байршуулах журам зэрэг нийт 8 журам батлан мөрдөж байна. Мөн Дотоод хяналт шалгалтын коммис, Архивын баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулан батлуулах, онлайн сургалтыг зохион байгуулах сургагч багшийн үйл ажиллагааны заавар, илүү цагаар ажиллах маягт, Шуурхай ажлын зааварчилгаа, 2014 оны авлигатай тэмцэх заавар, барилга түр хүлээн авах 3 талт акт, Инкубаторын компаниудтай байгуулах хамтран ажиллах гэрээ, Инкубаторын сонгон шалгаруулалтын ажлын хэсэгтэй байгуулах нууцын гэрээ, АБҮЗ-ын гишүүдтэй байгуулах гэрээний төсөл зэрэг баримт бичгийг эцэслэн батлууллаа.

		Түрээслэгч байгууллагуудтай 2014 оны гэрээг шинэчлэн байгуулах	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн Түрээсийн гэрээний сунгалтыг нийт 27 байгууллагатай байгуулж, батлуулсан.
		Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд /ЭБАТ/	МТҮП-ын 2014 оны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Баталгаажсан хувийг АТГ-т хүргүүлсэн бөгөөд холбогдох ажилчдад гүйцэтгэх ажлын мэдээллийг хүргүүлж байгууллагын Дропбокс -т байршуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан албан ёсны сургалтанд сууж холбогдох мэдээллийг авч ажилласан.
1.5.	Гадаад харилцаа, маркетингийн үйл ажиллагаа	МТҮП-ын хүний нөөц, удирдлагын чадварыг сайжруулах, гадаадын богино хугацааны сургалт семинарт хамруулах боломжийг судлах /60/	NIA, ITU байгууллага руу хүсэлт явуулж 7 сард сайн дурын ажилчдын 2 багийг хүлээн авч, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, сургалт зохион байгуулахаар болсон.
		Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинээр харилцаа тогтоох	Олон улсын ACM (Association for Computing Machinery-Цахим тооцооллын холбоо)-ын гишүүн байгууллага болсон. Ач холбогдол нь дэлхийн шилдэг ном, хэвлэлүүд ялангуяа МТ-ийн чиглэлийн номыг захиалах, унших, түүнчлэн дижитал номын санг ашиглах боломжтой болж байна.
1.6.	Санхүү, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Байгууллагын 2014 оны төсвийг ТУЗ-н хурлаар батлуулах	Байгууллагын 2014 оны санхүүгийн төсвийг ТУЗ,ТӨХ-оор тус тус батлуулан ажиллаж байна.
		Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх, тайлагнах	Хуулийн хугацаанд тайлагнах бүх тайланг хугацаанд нь гаргасан. Мөн нэмэлт төслийн аутсорсингийн тайланг ЗГХЭГ-т тайлагнаж 4,9 сая төгрөгийн үлдэгдлийг хаасан. ТӨХ-нд түрээсийн болон ҮХ-тэй холбоотой уламжлалт ТӨ-2 маягыг бөглөж тайлан хэлбэрээр гаргаж өгсөн. "Сүлд" аудитын шалгалттай холбоотой 19 асуулга, дүгнэлтэд хариу тайлбар хийж хүргүүлсэн. Үндэсний аутидын газраас ирүүлсэн 2013 оны тайлан мэдээтэй холбоотой тайланг цаг хугацаанд нь үнэн зөв бэлтгэж ажиллаа. Сангийн Яаманд 2013 оны тайлан мэдээг маягтын дагуу 2 удаа хүргүүлсэн. Санхүүгийн хянат шалгалттай холбоотойгоор ТӨХ-ны мэргэжилтэн Жанцанхорлоод 2012-2013 оны бшх мэдээллийг гаргаж өгч, шалтгалтаар зөрчилгүй дүгнэлт гаргасан.
		Байгууллагын мөнгөн болон биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах	Байгууллагын мөнгөн хөрөнгийн орлого зарлагын тайланг өдөр тутам анхан шатны баримтаар баталгаажуулан 7 хоног тутам орлого-зарлага, түрээсийн тооцоо мэдээллийг удирдлагуудад тайлагнаж хэвшсэн.
		Байгууллагын түрээсийн үйлчилгээг сайжруулж төсөвлөсөн орлогыг бүрдүүлэх	Энхий хагас жилийн байдлаар биелэлт 92,6%-тай байна.

		Санхүүгийн НББ-ийн шинэ програмтай болох	BAAZ програм дээр тайлан баланс хөтөлж байна.
		Байгууллагын 2014 оны батлагдсан төсвийн дагуу худалдан авалтын жагсаалт гаргах	Эхний ээлжинд нэн шаардлагатай ТТ-ийн жагсаалт гарган 1ш нөүтбүүк, 1ш Мас, 1 ш камерыг ХА-ын жишгийн дагуу авч нийлүүлж, албан хэрэгцээнд ашиглаж байна. Номын сангийн фондыг бүрдүүлэх зорилгоор 260 нэр төрлийн номын үнийн судалгааг СЗҮХ гаргаад байна.
1.7	Байгууллагын системийг удирдах үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Wiki системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Wiki-ийг үнэгүй хост дээр байрлуулсан. Үйл ажиллагаанд оруулахад бэлэн байна. Хаяг: itpark.0fees.net
2. Цахим засаглал, статистик хэрэгжүүлэлтийн чиглэлээр			
2.1.	Байгууллагын стратегиүйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх		<p>Shenzhen дахь Электроникийн томоохонд тооцогддог захыг судалсан. Мөн PCB(Printed circuit board) үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг, тухайн салбартаа нэр хүндтэй 3-5 компанийг судалж, гадаад харилцааны мэргэжилтэнтэй хамтран харилцаа тогтоосон. Ингэснээр Захирал тус компаниудад уригдан очиж, цаашид хамтарч ажиллах нөхцөл бүрдсэн. Үүний үр дүнд iPCB үйлчилгээг үзүүлж, хамтарч ажиллах боломж нээгдсэн. Энэ нь манай электроникийн салбарт тодорхой түлхэц болохуйц ач холбогдол бүхий харилцаа холбоо тавигдсан.</p> <p>МУИС-МТС-ийн сургуулийн электроникийн тэнхимийн багш Отгонцэцэгтэй хамтарч тус сургуулийн оюутнуудыг эмбеддэд систем чиглэлийн судалгаанд өргөнөөр хамруулах, судалгааны ажлыг биет зүйл болгох, цаашид өөрсдийн ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эмбеддэдийн тоног төхөөрөмж болон зарим материаллаг зүйлсээр хангаж, судалгааны үр дүнг албан журмаар танилцуулах зорилгоор хамтарч ажиллахаар болсон.</p>
3. Силикон Хаусын ажлыг тогтмолжуулах			
3.1.	Номын сангийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах		<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмж, эд хогшил байрлуулав. 2. Танилцуулгын материал гаргасан. 3. Мөрдөх журам, дүрэм гарган бэлтгэсэн. 4. Улсын комисс хүлээн аваагүй байгаагаас үйл ажиллагаа эхлээгүй байна. <p>Америкийн монгол судлалын төвтөй холбоо тогтоон өмнө авсан 1450 ширхэг номны ашиглалтын тайлан болон дахин ном авах хүсэлтийг бэлтгэн хүргүүлж 200 ширхэг номыг нэмж хүлээн аваад байна.</p>

3.2	Сургалтын төвийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах		<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмж, эд хогшил байрлуулав. 2. Танилцуулгын материал гаргасан. 3. Мөрдөх журам, дүрэм гарган бэлтгэсэн. 4. Үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон.
3.3	Эмбэдэд системийн лабораторийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах		<p>Эмбеддэд системийн лабораторийн тоног төхөөрөмжийг 100% хүлээж аваад байна. Лабораторын шинэ тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгаж үзэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Raspberry Pi- д Linux дээр суурилсан Rasbian үйлдлийн системийг суулгав 2. Risk үйлдлийн системийг суулгав 3. Wireless ба ethernet тохиргоог хийв. 4. Libre Office татаж суулгав.
3.4	Компьютер вишн лабораторийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах		<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмж, эд хогшил байрлуулав. 2.Танилцуулгын материал гаргасан. 3. Мөрдөх журам, дүрэм гарган бэлтгэсэн. 4. Үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон. Нээлтийн үйл ажиллагаа болон 2 хурал зохион байгуулсан.
4. Салбарын хүний нөөцийг чадваржуулах чиглэлээр			
4.1	Хүний нөөцийг чадваржуулах чиглэлээр	MSO-ийн сургалт зохион байгуулах	MSO-ийн сургалт зохион байгуулав. Сургалтыг МНБИ-тэй хамтран зохион байгуулав. 50 хүнтэй 2 ээлжээр амжилттай зохион байгуулсан (сургалтын нийт цаг 36 орлого)
		Сингапурын сургалт	Ухаалаг гар утасны сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хөтөлбөр гаргах, зар сурталчилгаа явуулах, хамтран ажиллах байгууллагыг сонгох зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Сургалтыг 8 сарын эхний 7 хоногт зохион байгуулахаар төлөвлөж байна.
		Бусад	"Эмбэдэд систем Монголд " онол практикийн бага хурлыг зохион байгуулж нийт 70 гаруй оролцогч нарыг хамарсан, Монгол улсын МТ-ийн хөгжил чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийв. Хурлын тайланг гаргав. МУИС-ийн биотехнологийн 2-р курсын 15 оюутанд байгууллагын үйл ажиллагааг танилцууллаа.
5. МТИШ-ыг зохион байгуулах, цар хүрээг өргөжүүлэх			

5.1	АБҮЗ-ийг хуралдуулах, шалгарсан асуултуудыг IPA-руу илгээх	<p>1. АБҮЗ-ийн гэрээг гишүүдтэй 1 жилийн хагацаагаар байгуулсан бөгөөд үйл ажиллагааны журмыг батлуулан мөрдөж эхэлсэн. 2014 оны нэгдүгээр хагас жилийн АБҮЗ-ийн 7 удаагийн хурлыг зохион байгуулав. Хурлаар нийт FE_АМ-ийн 32 асуулт, FE_РМ-ийн 4 асуулт, AP_АМ-ийн 11 асуултууд хэлэлцэгдэн шалгарав. Нийт 45 асуултыг хандивлав.</p> <p>2. АБЗ-ийн олон улсын хурлыг зохион байгуулсан. Уулзалтанд нийт 8 орны 27 оролцогч оролцов. Монгол улсаас хандивласан 45 асуултаас 7 асуулт тэнцсэн байна.</p>
5.2	МТИШ-ийн сургалтын бэлтгэл	<p>Хөдөө орон нутаг Ховд, Дархан-уул аймагт тус тус сургалт, шалгалтыг танилцуулах сургалт, семинар зохион байгуулж, МТИШ-ын 13 сургагч багшийг Дархан-уул аймагт бэлтгэж, гэрчилгээг олгосон төдийгүй, Ховд аймагт 72 оролцогчдыг хамруулсан семинар зохион байгуулав. Мөн Ховд их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна.</p> <p>Шатлаглтанд бэлтгэх сургалтанд Интерактив ХХК-иас 20 хүн,Интерактив Би Ай ХХК-иас 20, МТИСШ-нд 28, МТПШ-нд 8, Ховд аймгийн Ховд их сургуулиас 27 нийт сургалтанд хамрагдагчдын тоо 102. Өмнөх жилүүдээс 3 дахин их хүн сургалтанд хамрагдав.</p> <p>4 сарын 27-ны өдөр Монгол японы төв дээр шалгалт зохион байгуулав. МТПШ-нд 15 шалгуулагч, МТИСШ-нд 118 шалгуулагч, нийт 133 шалгуулагчийн ирцтэй байлаа. Нийт тэнцэгчдийн тоо 14</p> <p>ITPES-ээс ирүүлсэн шаардлагын дагуу онлайн бүртгэлийн шалгалтын формыг дахин хийсэн бөгөөд ажиллуулахад бэлэн болоод байна. Мөн Голомт банкнаас тавьсан шаардлага(SSL сертификат Real-IP)ыг гүйцэлдүүлэн SSL сертификаттай болоод байна.</p>
6. Бизнес инкубацийн орчинг сайжруулах, инкубаторыг ажиллуулах чиглэлээр		
6.1	Инкубаторын сонгон шалгаруулалт, үнэлгээ, дүгнэлт хийх	<p>1. Инкубаторын элсэлтийг 3 удаа зохион байгуулж нийт 64 оролцогч хамрагдав. Элсэлтийн зарыг өдрийн сонинд 2 удаа, холбогдох вэб сайтуудаар сурталчлав. Элсэлтэнд 19 компани иргэн оролцож, 5 компани 1 иргэн тэнцсэн. Одоогийн байдлаар 9 компани байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.</p>

		Инкубаторын сар тутмын үйл ажиллагааг дүгнэх ажлын хүрээнд инкубаторын үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн цагаас буюу 5-р сарын 8 аас эхлэн үнэлгээ, шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Үнэлгээнд 9 компани оролцож дүнг гаргав. Үнэлгээгээр 4-н компани А, 2 компани В, 2 компани С, 1 компани F тус тус үнэлгээтэй гарлаа.
6.2	Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх	<p>1.МТ-ийн бизнесийн болон боловсролын уулзалт, үзэсгэлэн, яармагт, нийт 6 компани, 10 оюутан бүтээлийн үзэсгэлэнгээр оролцон 1сая ₮ -ийн мөнгөн шагналаар шагнаан холбогдох мэдээллийн сайтаар мэдээлэн алдаршуулав.</p> <p>2.МТШХХГ-аас зохион байгуулсан ICTExpo үзэсгэлэнд МТҮП, МТ-ийн инкубаторын 9-н компани хамруулав. Энэ ажлын хүрээнд загвар гаргах, байгууламж барих зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>Start up case-ийн үйлчилгээг нэвтрүүлэн 2 компанид 200,000 ₮-ний цүнх, өдөр тутмын хэрэглээний бичиг баримт, эрхийн бичгийг гардуулав.</p> <p>8-н багц үйлчилгээнээс одоогийн байдлаар 9 компанид ажлын байрны нийт төлбөр 8,886,500-аас төлбөл зохих нь 888,650 хөнгөлөлттэй төлбөр 7,997,850 ₮-ны хөнгөлөлттэй үйлчилгээ, тамга тэмдгийн 42,400 ₮ өртөг бүхий үйлчилгээ, зар сурталчилгааны загвар /template/ нийт 3,927,550 ₮ үйлчилгээ үзүүлэв .</p> <p>Компаниудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилгоор захирлын уулзалтыг 4 удаа зохион байгуулав. Уулзалтаас компаниуд хамтран үзэсгэлэнд оролцох, зар сурталчилгааг хамтран гүйцэтгэх зэрэг олон бодит ажлыг хийж эхлүүлээд байна.</p> <p>9 компаниас 7,500,000 ₮ -ний барьцаа төлбөрийг барилуулав.</p>
7. Шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэлтийг дэмжих чиглэлээр		
7.1	Инкубаторын платформ өргөтгөх	Инкубаторын компаниудын үйл ажиллагаа, тайлан төлөвлөгөөг хялбаршуулах, хэрэглэгчтэй холбох програм хангамжийн нэгдсэн системийг ажиллагаанд оруулан хэвийн ажиллаж байна.
7.2	Асуулт боловсруулах зөвлөлийн платформыг өргөтгөх	Платформын үйл ажиллагааг Силикон Хаусын төслийн нээлттэй давхардсанаас ашиглалтанд ороогүй байгаа. Ажлын үйл явц хэрэглэгч онлайнаар бүртгүүлээд өөрийн асуултаа нэмэх, бусад хэрэглэгчдийн асуултанд санал өгөх боломжтой болсон.
8. Хамтын ажиллагаа болон бусад арга хэмжээ		

8.1	ОУ-ын хурал зохион байгуулах бэлтгэл ажил	<p>АСПА-ийн удирдлагуудын уулзалтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж, ажлын хэсгийг байгуулж батлуулсан. Мөн Ерөнхий захирал Ц.Түвшинтөрийн БНСУ-ын Тэгү хотод хийх айлчлалыг зохион байгуулсан. Айлчлалын үр дүнд АСПА Удирдлагуудын уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажил болон хөтөлбөр, уригдаж ирэх зочид илтгэгчдийн талаар ярилцаж тохиролцсон. Айлчлалын талаар АСПА болон МТҮП-ын вэб хуудсанд тавигдсан. АСПА Удирдлагуудын уулзалтанд оролцох компаниудын бүртгэлийн вэб хуудас хийхэд шаардлагатай мэдээллүүдийг бэлтгэж өгсөн, веб хуудас бэлэн болсон. aspa.itpark.mn</p> <p>АСПА- 9 дэх удаагийн уулзалт зохион байгуулав. Нийт 100 гаруй төлөөлөгч оролцсоноос Азийн 7 орны 27 төлөөлөгч, бизнесийн байгууллагаас 40, шинжлэх ухаан болон их дээд сургуулийн 40 гаруй төлөөлөгч оролцов. Уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсэг гарган төлөвлөгөө, төсөв гаргах, мэдээ мэдээллүүдийг гаргах, сурталчлах, шинээр байгууллагын танилцуулга гаргах гэх мэт зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэв.</p>						
8.2	<p>ICTЕхро болон салбарын ойн бусад арга хэмжээнд оролцох</p>	<table border="1"> <tr> <td data-bbox="682 764 1230 951">Спортын үйл ажиллагаа</td> <td data-bbox="1230 764 1923 951">Техникийн зөвлөлийн хуралд оролцон тэмцээнд оролцох ажилтнуудын зураг, үнэмлэх, байгууллагын туг далбай г.м шаардлагатай материалуудыг бэлтгэн дарц, эрэгтэй эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд оролцлоо. Тэмцээнд МТҮП-ын ажилтнуудаас гадна инкубаторын компаний ажилтнуудыг хамрууллаа.</td> </tr> <tr> <td data-bbox="682 951 1230 1045">Баярын хурал</td> <td data-bbox="1230 951 1923 1045">5-р сарын 28-нд Монголын үйлдвэрчний соёлын төв өргөөнд болсон 93 жилийн баярын хуралд бүх ажилтнууд оролцлоо.</td> </tr> <tr> <td data-bbox="682 1045 1230 1289">Үзэсгэлэн</td> <td data-bbox="1230 1045 1923 1289">5-р сарын 22-26 ны өдрүүдэд Мишээл төвд зохион байгуулагдсан ICTA expo-2014 арга хэмжээнд инкубаторын 7 компаний хамт талбайгаа тохижуулан оролцож байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчиллаа. Энэ ажлын хүрээнд төлөвлөгөө, төсөв зэргийг гарган тушаал батлуулж ажлын хэсгийн гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа.</td> </tr> </table>	Спортын үйл ажиллагаа	Техникийн зөвлөлийн хуралд оролцон тэмцээнд оролцох ажилтнуудын зураг, үнэмлэх, байгууллагын туг далбай г.м шаардлагатай материалуудыг бэлтгэн дарц, эрэгтэй эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд оролцлоо. Тэмцээнд МТҮП-ын ажилтнуудаас гадна инкубаторын компаний ажилтнуудыг хамрууллаа.	Баярын хурал	5-р сарын 28-нд Монголын үйлдвэрчний соёлын төв өргөөнд болсон 93 жилийн баярын хуралд бүх ажилтнууд оролцлоо.	Үзэсгэлэн	5-р сарын 22-26 ны өдрүүдэд Мишээл төвд зохион байгуулагдсан ICTA expo-2014 арга хэмжээнд инкубаторын 7 компаний хамт талбайгаа тохижуулан оролцож байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчиллаа. Энэ ажлын хүрээнд төлөвлөгөө, төсөв зэргийг гарган тушаал батлуулж ажлын хэсгийн гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа.
Спортын үйл ажиллагаа	Техникийн зөвлөлийн хуралд оролцон тэмцээнд оролцох ажилтнуудын зураг, үнэмлэх, байгууллагын туг далбай г.м шаардлагатай материалуудыг бэлтгэн дарц, эрэгтэй эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд оролцлоо. Тэмцээнд МТҮП-ын ажилтнуудаас гадна инкубаторын компаний ажилтнуудыг хамрууллаа.							
Баярын хурал	5-р сарын 28-нд Монголын үйлдвэрчний соёлын төв өргөөнд болсон 93 жилийн баярын хуралд бүх ажилтнууд оролцлоо.							
Үзэсгэлэн	5-р сарын 22-26 ны өдрүүдэд Мишээл төвд зохион байгуулагдсан ICTA expo-2014 арга хэмжээнд инкубаторын 7 компаний хамт талбайгаа тохижуулан оролцож байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчиллаа. Энэ ажлын хүрээнд төлөвлөгөө, төсөв зэргийг гарган тушаал батлуулж ажлын хэсгийн гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа.							

8.3	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар буюу төлөвлөгдөөгүй ажил	МТШХХ-ын салбарын эрх зүйн шинэчлэл 2014 нээлттэй өдөрлөг	“Эрх зүйн шинэчлэл” нээлттэй хэлэлцүүлгийн хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажилд МТҮП-аас Oloo.mn, MGLtime.com, Zindaa.mn сайтуудад баннер байрлууллаа. Мөн байгууллагын веб сайт болон твиттер хуудсаар зар мэдээллийг тавьж, Улс төрийн тойм сонинд арга хэмжээ болох талаар мэдээ өглөө. Ажлын тайлан болон захирлын илтгэлийг агентлагын мэргэжилтэн Нэргүйд өглөө. Нээлттэй хэлэлцүүлэг 2014.01.15 -нд төрийн ордон болсон бөгөөд МТҮП-ын танилцуулга баннер байрлуулан байгууллагаас 16 хүн оролцлоо.
		RFID карт уншигч	Силикон хаус төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Эмбеддэд системийн лабораторийн тоног төхөөрөмжийг энгийн практикт ойр демо бүтээгдэхүүн гаргах зорилгоор нэвтрэх системээр ашиглах зориулалт бүхий эмбеддэд систем гаргах чиглэлээр ажилласан. Тус систем нь нэвтрэх системийн зориулалтаар ашиглах бүрэн боломжтой демо хувилбар юм. Энэхүү эмбеддэд систем нь програм хангамж буюу өгөгдлийн сантай хэрхэн хамтарч ажиллаж, нэвтрэх системийн дотоод сүлжээнд холбогдсон үүгээрээ хяналт, удирдлагыг сайжруулсан, уян хатан, энгийн болон өргөтгөх боломжуудтай зэрэг давуу талуудыг өөртөө агуулсан систем болж чадсан юм. "Монгол толгой - Силикон хаус" төслийн нээлтэнд олон нийтэд танилцуулсан бөгөөд сонирхогчдыг ихээр татаж байлаа.
		Тамхины утаа мэдэрч зураг авах демо боловсруулах	Силикон хаус төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Эмбеддэд системийн лабораторийн тоног төхөөрөмжийг энгийн практикт ойр демо бүтээгдэхүүн гаргах зорилгоор тамхины хуулийн биелэлтэнд хяналт тавих зориулалт бүхий эмбеддэд систем гаргах чиглэлээр ажилласан. Тус систем нь дэлхийн бренд болсон нээлттэй эх дээр суурилсан хавтан болох Arduino Uno болон бусад хэрэгцээт модулуудыг ашиглан, тамхины утаа мэдрэн тухайн объектийн зургийг авч SD картанд хадгалах төхөөрөмжийг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр эмбеддэд системийн лабораторид ашиглагдах микропроцессор болон бусад модулуудыг ашиглан энгийн системүүдийг хийх, демо хэлбэрээр хийж ашиглах боломжтой гэдгийг "Монгол толгой - Силикон хаус" төслийн нээлтэнд олон нийтэд танилцуулсан.

	Уран зургийн уралдаан	МТ-ийн инкубаторын орчинг тохижуулах зорилгоор зарласан уран зургийн уралдаанын зохион байгуулсан бөгөөд уралдаанд нийт 9-н зураачийн 10-н уран бүтээл ирснээс энхний 3-н байрыг шалгаруулав. 1-р байр Д.Дашдоржын /Хувцас бурхан бие чөтгөр/ 2-р байр Б.Золбоо /Харилцаа/ 3-р байр Д.Уянга /IT-Төгс амьдрал/. 10 уран бүтээлээс 1 уран бүтээлийг буцаан олгож одоогийн байдлаар 9 зурагтай байна.
	Ижил төрлийн байгууллагуудад цалингийн судалгаа хийж танилцуулах.	Ижил төстэй 6 байгууллагын цалингийн судалгаа хийж тайлан мэдээ боловсруулсан. Үүний үр дүнд ажилтнуудын цалинг тодорхой хувиар нэмэгдүүлээд байна.
	Тайлан төлөвлөгөөг нэгтгэх, дээд байгууллагт мэдээлэх	<p>2013 оны үйл ажиллагааны тайлан, СБХТ-ийн статистик мэдээлэл, Ерөнхий захирлын үр дүнгийн гэрээ зэргийг нэгтгэн МТШХХТГ-т хүргүүлээ. Мөн 2014 оны үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан батлуулж агентлагт хүргүүлээд байна.</p> <p>ТӨХ-оос ирсэн албан тоотын дагуу бүтэц орон тоо, сүүлийн 3 жилийн орлого зарлагын ерөнхий тайлан, 2013 оны үйл ажиллагааны танилцуулга, цаашид төлөвлөж буй ажлуудын товч танилцуулга зэрэг материалыг бэлтгэн хүргүүлээ.</p>
	Бизнесийн үйл ажиллалааг дэмжих, хамтран ажиллах бололцоог хангах	<p>Coworking space -1 нэвтрүүлж 4-н удаа уулзалтыг зохион байгуулав. Grafх компани 2 удаа уулзалт зохион байгуулсан.</p> <p>Дэвшилтэт үйлчилгээний нэг болох виртуал оффисын үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажиллагааг ханган тавигдах шаардлага, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлон мэдээллийн сайтуудад байрлуулав.</p>
	Сугалааны програм хангамж хөгжүүлэх	Сугалааны програм хангамж хөгжүүлэх, сугалаа програмыг хөгжүүлж дууссан. Програмын эцсийн үр дүнг танилцуулсан.
	2013 оны үйл ажиллагаатай холбоотой материалуудыг архивлах	2013 оны үйл ажиллагаатай холбоотой материалыг архивлах ажил дууссан.
	МТИСШ-ыг өргөжүүлэх	ТАЗ-тэй хамтран МТИШ болон CDIL шалгалтыг төрийн албанд нэвтрүүлэх, сургалтыг хамтран зохион байгуулах талаар хамтран ажиллахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
	Ази номхон далайн бүс нутгийн Кибер аюулгүй байдлын форумын зохион байгуулалтанд ажиллах	5 сарын 24-26-нд Ази номхон далайн бүс нутгийн Кибер аюулгүй байдлын форумын ажлын хэсэгт зочдыг тосож авах, хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаанд туслах, гадаадын төлөөлөгчдыг дагуулж явах зэрэг ажилд хамтран ажиллалаа.

		Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, сүлжээ серверийн асуудлууд	Үндэсний дата төв дээр байрлах виртуал серверүүд хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.Тоног төхөөрөмж, Компьютер, Сүлжээний төхөөрөмжүүд болон серверүүдийн хэвийн ажиллаж байна. Үндэсний дата төв УТҮГазарт байрлах Real АйПи 103.9.9.162/28 ... гэх 6 хаяг хэвийн ажиллаж байгаа болноо. Төслөөр нийлүүлэгдсэн шинэ тоног төхөөрөмжүүдийг паспортжуулах ажил хийгдэж байна.Байгууллагын хэмжээний ерөнхий сүлжээний схем,диаграмм зураг гаргаж байна.
		Аутсорсингийн хэлэлцүүлэгт оролцох	Аутсорсинг хөгжүүлэх, аутсорсингийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар 2006-2010 онд Паркаас хэрэгжүүлсэн бүх ажлын Хөдөлмөрийн бирж дээр илтгэл хэлэлцүүлэх, MN2 TV-д ярилцлага өгөв.
8.4	Үйл ажиллагааны сурталчилгаа хийх	Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааг идэвхижүүлэх	Байгууллагын веб, твиттер, фэйсбүүк хуудсуудаар Инкубатор, МТИШ, Силикон Хаус төсөл, Азийн шинжлэх ухааны паркуудын удирдлагуудын болон бусад үйл ажиллагаатай холбоотой 30 гаруй мэдээлэл тавигдлаа.
		Шалгалтын зар, сурталчилгаа	Үйл ажиллагааг хэвийн явуулах, олон нийтэд хүргэх зорилгоор мэдээллийн технологийн харьяа байгууллагууд болон их дээд сургуулийн нийт 8 мэдээллийн сайт, Монголын үндэсний ТВ болон Ховд аймгийн Ховд ТВ тай хамтран ажиллаж шалгалтын сурталчилгаа явуулав.
		Хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр	Силикон Хаус төслийн нээлт болон Азийн шинжлэх ухааны паркуудын удирдлагуудын 9 дэх уулзалтын үйл ажиллагаануудтай холбоотойгоор 10 гаруй. Телевиз, 20 гаруй веб сайтаар үйл явдлын мэдээллийг гарган, сурвалжлага бэлтгүүллээ.
			Салбарын цагаан номонд орох байгууллагын танилцуулгыг бэлтгэн МТШХХТГ-т илгээв.
			МТШХХТГ-аас сар бүр нийтлэгддэг IT news сэтгүүлд Силикон хаусын зураг, болон танилцуулга мэдээллийг бэлтгэн өглөө.
Stocklayouts -оос сурталчилгааны материалд ашиглагдах загварууд татаж авах	Байгууллагын танилцуулга, сурталчилгаанд ашиглах зорилгоор Stocklayouts -оос 120 загвар татаж аван 9-ийг нь хэрэглээд байна.		
8.5	Байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах, тасралтгүй үйл ажиллагаагаар хангах	Дээд байгууллагыг мэдээллээр хангах, хамтын ажиллагааг идэвхижүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийн 2013 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж байгаатай холбоотойгоор өөрийн байгууллагын хариуцсан арга хэмжээний тайланг хавсралтын дагуу бэлтгэн МТШХХТГ-т хүргүүллээ.

			<p>2013 онд батлагдсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн дагуу төрийн өмчит болон төрийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газруудын хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ажил, МТ-ийн техник, т.т-ийн судалгаа зэргийг бөглөн ТӨХ-д хүргүүллээ.</p>
		<p>Ажилтнуудад удирдлагаас өгч буй үүрэг даалгаварыг бүртгэлжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавих удирдлагт танилцуулах</p>	<p>Нийт 160 үүрэг даалгаврын хуудас гарсанаас гүйцэтгэл 90% тай байна. Силикон Хаус төслийн нээлт болон барилгын ажилтай холбоотойгоор 4,5-р сард хамгийн их үүрэг даалгавар өгөгдсөн байлаа.</p>

Жич: СБХТ-ийн статистик мэдээлэлтэй хавсралт 1-ээс танилцна уу.

ХАВСРАЛТ-1: СТРАТЕГИ, БИЗНЕС ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Статистик мэдээлэл

д/д	Ажлын нэр	тоо хэмжээ	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Сургалт	7	172	
2	Семинар	4	117	
3	Инкубаторын элсэлт	2	25	7 /тэнцсэн/
4	Шалгалт	2	142	
5	Үзэсгэлэн	1	100	
6	Инкубаторын захирлын уулзалт	2	16	
7	Эрдэм шинжилгээний хурал	1	70	
	Нийт	19	642	

МТ-ий салбарын хүний нөөцийг хөгжүүлэх

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Дархан-Уул аймагт сургагч багшийн сургалт	1	2014.03.08-03.10	МТИШ-ын сургагч багш бэлтгэх сургалт	13	13	Б.Батням (МУИС) багш удирдан зохион байгуулав.
2	МТПШ-нд бэлтгэх сургалт (ХААИС)	1	2014.03.31-04.18	МТПШ-нд оролцогчдод амжилттай дүн үзүүлэх	14	14	ХААИС-ийн баг зохион байгуулав.
3	МТИСШ-нд бэлтгэх сургалт (Интерактив Би Ай ХХК)	1	2014.04.01-04.19	МТИСШ-нд оролцогчдод амжилттай дүн үзүүлэх	20	19	ШУТИС-КТМС-ийн баг зохион байгуулав.
4	МТИСШ-нд бэлтгэх сургалт (Интерактив ХХК)	1	2014.04.01-04.19	МТИСШ-нд оролцогчдод амжилттай дүн үзүүлэх	20	19	МУИС-МТС-ийн баг зохион байгуулав.
5	МТИСШ-нд бэлтгэх сургалт (МУИС-МТС)	1	2014.03.31-04.18	МТИСШ-нд оролцогчдод амжилттай дүн үзүүлэх	28	28	ШУТИС-КТМС-ийн баг зохион байгуулав.
6	МТПШ-нд бэлтгэх сургалт (Ховд аймаг)	1	2014.03.31-04.18	МТПШ-нд оролцогчдод амжилттай дүн үзүүлэх	27	27	ХИС-ийн баг зохион байгуулав.
7	MS оффисын сургалт	1	2014.04 сарын 28	Мэргэшсэн ня-бо нарт MSO анхан болон дунд шатны сургалтыг зохион байгуулав	100	52	МТҮП болон МНБИ
8	Шнейдер электроникс	1	2014.05.09	Шнейдер электроникс өөрийн ажилчиддаа зориулж ажилчидынхаа ур чадварыг дээшлүүлэх сургалт	50	50	Сургалтын танхим түрээс
Нийт		8			272	222	

МТИСШ-нд бэлтгэх сургалт

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тэнцэгчийн тоо	Тайлбар
1	МТПШ	1	2014.04.27	Бүх нийтийн МТ-ийн мэдлэгийг дээшлүүлэх	17	15	7	Монгол-Японы төвд болов
2	МТИСШ	1	2014.04.27	МТ-ий салбарын хүний нөөцийг хөгжүүлэх	136	118	7	Монгол-Японы төвд болов
	Нийт	2			153	133	14	

Албан бус шалгалт

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тэнцэгчийн тоо	Тайлбар
1	МТПШ	1	2014.05.09	ХААИС-ийн багш нарын МТ-ийн ур чадварыг шалгах	8	8	2	МТПШ-ын 2013 оны намрын шалгалтын материалаар МТҮП дээр авав
	Нийт				8	8	2	

Инкубаторын үйл ажиллагаа

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Инкубаторын 21 дэх элсэлтийн сонгон шалгаруулалт	1	2014.01.10	Эмбэддэд систем хөгжүүлэлт, компьютерийн дүрслэлийн лабораторит ажиллах компанийг түлхүү элсүүлэх бодлого барьсан.	8	6 компани, 2 иргэн	Хайрхан семикондакторс ХХК, Интер актив систем ХХК, Sebtion ХХК, EASS ХХК, We can do systems ХХК гэсэн 5 компани тэнцсэн.
2	Уран зургийн уралдаан	1	2014.01.17	Инкубаторын орчны тохижилтонд	10	9	
3	Элсэгчдэд зориулсан семинар	2	2014.04.18/25	Шинээр элсэгчдэд зориулсан семинар		25	
4	Инкубаторын 22 дахь элсэлтийн сонгон шалгаруулалт	1	2014.05.13	Гарааны компанийг элсүүлэх	12	11	Иргэн Лхагвасүрэн, Монгол эмбэддэд систем ХХК гэсэн 2 компани тэнцсэн.
5	Элсэгчдэд зориулсан семинар	2	2014.05.30 2014.06.06	Шинээр элсэгчдэд зориулсан семинар		17	
	Нийт	7			30	70	

Хурал

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Embedded systems -in Mongolia эрдэм шинжилгээний бага хурал	1	2014.05.08	Эмбэдэд системийн хөгжил, тулгамдаж буй асуудлын талаар нийт 8 илтгэгч илтгэл хэлэлцүүлэв	100	70	МТҮП
2	ОУ-ын асуулт боловсруулагчдын уулзалт	1	2014.06.04-06.06	FE болон AP шалгалтын асуулт сонгох хурал	27	27	МТҮП
3	АСПА-ийн олон улсын хурал	1	2014.06.19-21	Азийн ШУП-ын удирдлагууд, бизнес уулзалт	100	100	МТҮП
	Нийт	3			227	197	

Үзэсгэлэн

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Зориулалт	Хаана	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Бизнесийн болон боловсролын салбарын уулзалт, үзэсгэлэн, яармаг	1	5/9/2014	МТ-ийн чиглэлээр бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд таниулан суртчилах, оюутан залууст тогтвортой ажлын байраар	МТҮП	7-н компани 18-н оюутан бүртгүүлэв.	4 компани, 18 оюутан	Энэ үзэсгэлэнгээр нийт 3 байр шалгаруулсан. 1. ШУТИС-КТМС Уламбаяр, Даваажаргал 2. ШУТИС-МХТС Төртүвшин 3. ШУТИС-МХТС Хүрэлчулуун
2	ICTЕхро үзэсгэлэн	1	5/22 - 5/26	МТ-ийн чиглэлээр бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд таниулан суртчилах	Мишээл экспо	МТҮП болон 7-компани	МТҮП, Алкэмист техноложист, Монгол эмбэддэд систем, Интер актив систем, Sebtion тус тус оролцов.	
	Нийт	2						

Инкубаторын компаниудын захирлуудын уулзалт

д/д	Нэр	Оролцсон компанийн тоо	Хэлэлцсэн асуудал	Хугацаа	Тайлбар
1	Уулзалт 1	7-6	Хамтын ажиллагааны гэрээ байгуулах, өрөө хувиарлалт	2014.04.23	2014 оны 04-р сарын 23ны уулзалтанд Хайрхан семикондакторс компанийн захирал ирээгүй
2	Уулзалт 2	9-8	1. Барилгын засвар 2. Хамтын ажиллагааны гэрээ 3. Барьцаа төлбөр 4. Өрөөний хуваарилалт 5. ICTExpo үзэсгэлэн яармаг	2014.05.14	2014 оны 05-р сарын 14ны уулзалтанд Монгол эмбэддэд систем компанийн захирал ирээгүй
Нийт	2	8			

Семинар

№	Нэр	Зохион байгуулсан тоо	Огноо	Хаана	Зориулалт	Бүртгүүлэгчдийн тоо	Оролцогчдын тоо	Тайлбар
1	Шалгалт танилцуулах семинар	1	2014.03.14	Ховд аймаг	МТИШ-ыг таниулах, сургагч багш нарт мэдээлэл зөвлөгөө өгөх	64	72	Ц.Түвшинтөр (МТҮП), Б.Батням (МУИС), Батсайхан (ХИС), Т.Буяндэлгэр (ХИС) нар илтгэл тавив.
2	Шалгалт танилцуулах семинар	1	2014.03.24	ХААИС		30	30	Энэрэлт, Сувд 2 танилцуулав
3	Шалгалт танилцуулах семинар	1	2014.03.28	Интерактив ХХК		15	15	Энэрэлт, Сувд 2 танилцуулав
4	МТ-ийн шалгалтыг танилцуулах семинар	1	2014.09 сард		МТИШ-ыг танилцуулах семинар			IPA болон МТҮП
	Нийт					109	117	